



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А/734

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн “а”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Баттод” ХХК-ний хийж гүйцэтгэсэн Жаргалант сумын багуудын нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг, камержуулалтын ажил /2-р багц/-н ажлын тоо хэмжээнд зөрүү гарсантай холбогдуулан нэмэлтээр хийгдсэн ажлыг нягтлан шалгаж нэмэлт гэрээ байгуулан санхүүжилтийг шийдвэрлэх боломжтой эсэх талаар шийдвэр гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Баярсүх - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд:

Б.Түмэндэмбэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Н.Ганзориг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрхзүйн хэлтсийн дарга

Ц.Равданпүрэв - Ховд аймаг дахь Цагдаагийн газрын Аж ахуйн офицер, цагдаагийн ахмад

Б.Мөнхтулга - Ховд аймаг дахь Цагдаагийн газрын Холбоо мэдээлэлийн инженер, Цагдаагийн дэслэгч

Ч.Баттулга - “Баттод” ХХК-ний захирал


Нарийн бичгийн
дарга: Д.Эрдэнэбат

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн гэрээт ажилтан

2. Тус ажлыг шийдвэрлэх боломжтой эсэх талаар ажлын хэсгийн дүгнэлтийг 2020 оны 11 дугаар сарын 30-ны өдрийн дотор багтаан гаргаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/57 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН